



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ



ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

ТАНИЛЦУУЛГА, МЭДЭЭЛЭЛ

Мэндчилгээ



Хүртээмжтэй нийгмийн төлөө Хүн бүрийн оролцоог дэмжье!

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас эрхлэн гаргаж буй сэтгүүлийн эхний дугаараар та бүхэнтэйгээ мэндчилж байгаадаа туйлын баяртай байна.

Монгол улс хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах НҮБ-ын конвенц, түүний нэмэлт протоколд 2009 онд нэгдэн орсон. Тус конвенцийн үзэл баримтлалд тулгуурлан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг боловсруулж УИХ-аас 2016 онд баталсан. Уг хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенц, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, салбар дундын уялдаа холбоог хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр үндэсний хэмжээнд ажиллах хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага байгуулахаар хуульчилсан. Энэхүү хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын их хурлын 2018 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн 56 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 250 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 09 дүгээр сарын 04-ны өдрийн А/233 дугаар тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар байгуулагдан үндсэн дөрвөн газар, нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна.

Өнгөрсөн онд иргэдийнхээ дуу хоолойг сонсож, тэдэнд тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэж, цаашид хэрхэн хамтарч ажиллах, юуг анхаарах гээд ирэх онд хэрэгжүүлэх ажлын чиглэлийг тодорхойлсон их ажлын жил болж өнгөрлөө.

2019 оныг Монгол Улсын Засгийн газраас “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгон зарласан, мөн өнгөрсөн онд иргэдээс өгсөн санал, хүсэлт болоод тэдний эрхийг хангах, оролцоог нэмэгдүүлэх, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал зэрэг олон тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлүүлэхэд төр, төрийн бус байгууллага, иргэд, аж ахуй нэгж байгууллагууд, олон улсын байгууллагууд та бүхний оролцоо, хамтын ажиллагаа чухал төдийгүй бидэнтэй нэгэн үзүүрт хоёргүй сэтгэлээр хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

2019 он бидний хувьд хийж бүтээх зүйл ихтэй, арвин ололт, амжилтын жил болох болтугай. Хүртээмжтэй нийгмийн төлөө хүн бүрийн оролцоо тэгш байж, айл бүхэн аз жаргалтай, ажил үйлс нь өөдлөн дэвжиж явахыг хүсэн ерөөе.

ХБХХЕГ-ын дарга

Ц.ГАНЧИМЭГ


ТАНИЛЦУУЛГА

Мэргэжлийн боловсролын сургууль, Протез, ортопедийн үйлдвэр 1999 онд нэгдэж Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төв болсон ба 2006, 2012, 2016 онуудад тус тус бүтцийн өөрчлөлт хийгдэж 2018 онд Сэргээн засалт сургалт, үйлдвэрлэлийн төв болон өргөжин тэлсэн. Тус төвийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх замаар УИХ-ын 56 дугаар тогтоол, Засгийн газрын 250 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/233 дугаар тушаалаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяанд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар байгуулагдан ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар нь хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш эрх болон нийгмийн хамгааллын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд бүрэн дүүрэн оролцох, ая тухтай амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлийн талаарх эерэг ойлголт, хандлагыг олон нийтэд төлөвшүүлэх, тэдэнд ээлтэй нийгмийн орчинг бүрдүүлэх, сэтгэл зүй, эрүүл мэндийн хувьд нөхөн сэргээхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэгтэй ажиллаж байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжил, хамгааллын талаарх Засгийн газрын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах, бие даан хөгжих чадварыг эзэмшүүлэх замаар амьдралын чанарыг нь дээшлүүлэхэд оршино.





МОНГОЛ УЛСЫН ИХ ХҮРЛЫН ТОГТООЛ

2018 оны 6 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 56

Улаанбаатар хот

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч"-ийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" гэсэн хэсгийг "12. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар" гэж нэмсүгэй.

2. Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч"-ийн "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" гэсэн хэсгийг "12. 13, 14, 15, 16, 17, 18, 19" дэх дугаарыг "13, 14, 15, 16, 17, 18, 19, 20" гэж тус тус өөрчилсүгэй.

3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн батлагдсан төсөв, орон тооны хязгаарт багтаан байгуулж ажиллуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасгай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХҮРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 8 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 250

АГЕНТЛАГ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 183 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1, 9.1, Улсын Их Хурлын 2018 оны 56 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрыг байгуулсугай.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын орон тооны дээд хязгаарыг 35 байхаар тогтоосугай.

3. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар шинээр байгуулагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзоригт даалгасугай:

3.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын орон тоо, төсөв, хөрөнгийг өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа Сэргэн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн батлагдсан төсөв, орон тоо, үл хөдлөх болон эргэлтийн хөрөнгөөс шилжүүлэн зохицуулалт хийж шийдвэрлэх;

3.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, Сэргэн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг баталж мөрдүүлэх;

4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын үйл ажиллагаанд шаардлагатай нэмэлт зардлыг төсвийн ерөнхийлөн захирагчийн батлагдсан төсвийн хүрээнд зохицуулалт хийх замаар шийдвэрлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт зөвшөөрсүгэй.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн "Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 4 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийн жагсаалт"-ын "Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд" гэсэн заалтын "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" гэсэн баганад "13. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар" гэж нэмсүгэй.

6. Мөн тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийн жагсаалтын "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" гэсэн хэсгийн "13, 14, 15, 16, 17, 18, 19" гэсэн дугаарлалтыг "14, 15, 16, 17, 18, 19, 20" гэж өөрчилсүгэй.

7. Мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Засгийн газрын агентлагийн орон тооны хязгаар"-т дор дурдсан агуулгатай 27 дахь хэсэг нэмсүгэй:

8. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзоригт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

У.ХҮРЭЛСҮХ

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

Хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын нэгэн адил иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгэм, соёлын бүхий л эрхийг ямар нэг алагчлалгүйгээр эдлэхийн тулд хөдөлмөр эрхлэх, дэд бүтэц, мэдээллийн хүрээмжийг нэмэгдүүлэх, нийгмийн оролцоог хангаж өгөх зайлшгүй шаардлагатай байна гэж үзэж БХХХГ нь дараах тэргүүлэх чиглэлийг тодорхойлоод байна.

- Монгол улсын хууль тогтоомж болон Олон улсын гэрээ, конвенцын харилцан хамаарлын ойлголтыг дагаж мөрдүүлэхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар баримталж буй бодлогыг салбарын бодлого, хөтөлбөрүүдтэй уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг хангах, салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй холбоотой хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал боловсруулж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх, мөн хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм, журам, стандартыг боловсруулж батлуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зохих байр суурь бий болгох, тэгш эрхийг хангах, оролцоог дэмжих үүднээс олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллага, түүний дотор хууль эрх зүйн этгээд, төрийн албан хаагчдад ялгаварлан гадуурхалт болон тэдний өвөрмөц хэрэгцээний талаар шаардлагатай сургалт, нөлөөллийн ажлыг үе шаттай зохион байгуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүний эрхийн хараат бус эзэмшигчид болгон тэдний талаар нийгэмд эерэг дүр зураг бүрдүүлэн ойлголт бий болгох, бэхжүүлэх;
- Мэдээлэл, харилцаа холбоо, технологид нэвтэрхэд үүсэх саад бэрхшээлийг арилгах замаар хөгжлийн бэрхшээлтэй

хүмүүсийн нийгмийн оролцоог дэмжих, хүртээмжтэй орчныг бий болгох, боломжийг нэмэгдүүлэх, хүртээмжийн талаарх төрийн бодлогыг өргөжүүлэх;

- Эрдэм судлал, уран бүтээл, улс төр, нийгмийн идэвхээр дамжуулан соёлын бүх хүрээ, түүхийн үе шатуудад хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголтыг тодруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралаас олсон туршлага, мэдлэг, чадварыг дэмжих, нийгмийн өөрчлөлтөд тэднийг хамгаалах, хөгжлийн бэрхшээл судлал нь салбар дундын шинжлэх ухаан болохыг нотлох, эрдэмтэн судлаачдын судалгааны ажлын чиглэлийг тус шинжлэх ухаанд хандуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг хамгийн багадаа 4%-ийн үзүүлэлттэй байх шаардлагын хэрэгжилтийн тогтолцоог сайжруулах, квотын системийг хянах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхэд тулгуурласан загварыг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нас, хүйс, бэрхшээлийн хэлбэр, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажилладаг байгууллага, боловсон хүчний статистик, тоо мэдээлэл судалгааг гаргах, боловсруулах замаар хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдээллийн нэгдсэн санг бий болгох, бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх цахим мэдээллийн нэгдсэн сүлжээг боловсронгуй болгож, төрийн зохих байгууллагуудын сүлжээ, мэдээлэлтэй нэгдмэл байдлыг хангах;
- Олон улсын гэрээ, конвенц болон үндэсний хууль тогтоомжийн зарчимд бүрэн нийцсэн, үр дүнг хангасан,

хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх оролцоог дэмжсэн төсөл, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхэд гадаад дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах, гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Дээрх тэргүүлэх чиглэлийн хүрээнд ХБХХЕГ нь цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлт, дэд бүтэц, мэдээллийн хүртээмж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн оролцооны чиглэлээр бодлогын түвшинд тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Тухайлбал:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр:

1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулах цэгийг орон нутагт бий болгох;

1.2. Мэргэжлийн ур чадвар олгох сургуульд суралцагчдыг ажлын байранд бэлтгэх хөтөлбөрийг ажил олгогчидтой хамтран хэрэгжүүлэх;

1.3. Амжилттай хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг олон нийтэд сурталчлан таниулах;

1.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн төслийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулах;

1.5. Хөгжлийн бэрхшээлтэй ажил эрхлэх боломжтой иргэдийн судалгаа гаргах;

1.6. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилтэнд мэргэжлийн байгууллагуудтай хамтарч хяналт тавих, хэрэгжилтийг сайжруулах;

1.7. “Хөгжлийн сан” байгуулах тухай асуудлыг судлан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд санал боловсруулж хүргүүлэх;

1.8. Ерөнхий газрын дэргэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн бирж байгуулах.

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийн чиглэлээр:

2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар төрөөс хэрэгжүүлж

байгаа бодлого, арга хэмжээний талаарх мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр олон нийтэд түгээх;

2.2. Дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, хүртээмжийн үнэлгээ хийж санал, зөвлөмж хүргүүлэх;

2.3. Нийтийн тээврийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах;

2.4. Хүртээмжтэй орчин бүрдүүлэх уриалга гаргаж, хэрэгжилтэд хяналт тавих;

2.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн статистик мэдээ, судалгаа, бүртгэлийг холбогдох газруудаас татан авч, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх.

3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дээшлүүлэх чиглэлээр:

3.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг дээшлүүлэх нөлөөллийн сургалтыг улсын хэмжээнд зохион байгуулах;

3.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлж, “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үнэмлэх олгох журам, үнэмлэхийн загвар”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам”, “Мэргэжлийн ур чадварын олон улсын тэмцээнд амжилттай оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүнд урамшуулал олгох”, “Хөтөч нохойг сургах, ашиглах журам”-ын хэрэгжилтийг хангах;

3.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах, халамжийн болон түрээсийн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх, холбогдох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах;

3.4. Хүчирхийлэлд өртсөн хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй харилцах харилцаа болон хөгжлийн бэрхшээлийн талаарх сургалтыг цагдаа, нийгмийн ажилтнуудад зохион байгуулах;

3.5. ЕБС-ийн бага ангийн сурагчдад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх хандлагыг төлөвшүүлэх талаар ЕБС-ийн бага ангийн сургалтын хөтөлбөрт санал хүргүүлэх;

3.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн амьдралд оролцоход нөлөөлж буй хүчин зүйлийн судалгаа хийх.

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХАД ТӨР, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТҮНШЛЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” СЭДЭВТ ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН БОЛЛОО

НҮБ-ын Ерөнхий ассамблейгаас жил бүрийн 12 дугаар сарын 03-ны өдрийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах олон улсын өдөр болгон тэмдэглэхээр бүх гишүүн орнууддаа уриалсан. 1992 оноос хойш энэ өдрийг өдгөө 26 дахь удаагаа дэлхий нийтээрээ тэмдэглэн өнгөрүүлж байна. Жил бүр НҮБ-аас уриалга дэвшүүлж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг санал болгодог ба 2018 оныг НҮБ-аас “Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоо, тэгш байдлыг хангаж эрх мэдэлжүүлэх нь” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэхийг уриалсан юм. Монгол улс тус өдрийг тохиолдуулан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад төр, төрийн бус байгууллагын түншлэлийг бэхжүүлэх нь” сэдэвт чуулганыг үндэсний хэмжээнд амжилттай зохион байгуулж ажиллалаа.

Уг чуулганы арга хэмжээнд УИХ, Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн төр, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, олон улсын байгууллагын 700 гаруй төлөөлөгчид оролцсон байна.

Чуулганаар хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, оролцоог бодит болгоход тулгамдаж буй хөдөлмөр эрхлэлт (ажлын байр, урамшуулал, квотын систем, хууль болон төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт, хяналт г.м), боловсролд тэгш хамруулах (боловсролын байгууллагуудын тогтолцоо, хөтөлбөр, хүртээмж, сурах бичиг, ном гарын авлага, элсэлтийн журам, багшлах боловсон хүчин, багшийн ур чадвар г.м), дэд бүтэц, мэдээллийн хүртээмж (стандарт, хуулийн хэрэгжилт, ойлголт хандлага г.м) зэрэг асуудлуудыг хөндсөн үндсэн




илтгэлүүд тавигдаж, хэлэлцүүлэг өрнөсөн. Энэхүү хэлэлцүүлгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд салбар дундын оролцоо, хамтын ажиллагааг тодорхойлох, ил тодоор төр засаг, олон нийтийн анхааралд хүргэх, шийдвэрлэх арга зам, төр, төрийн бус байгууллагын оролцоог тодорхой болгохыг зорьсон билээ.

“ДЭЛХИЙН ГЭР БҮЛИЙН ӨДӨР”-ИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛДЭГ БОЛЛОО

Гэр бүл нийгмийн хамгийн бага нэгж хэдий ч асар их үүрэг, хариуцлага үүрч улс эх орны үндэс суурь нь болж өгдөг онцлогтой. Энэхүү хэлхээг бат бөх байлгах үүднээс НҮБ-ын Ерөнхий ассамблей 1993 оны 9-р сарын 20-ны хэлэлцээрээр 1994 оноос эхлэн жил бүрийн 5-р сарын 15-ны өдрийг “Гэр бүлийн өдөр” болгох тогтоол баталсан. Тус өдрийг дэлхий нийтээрээ тэмдэглэж өнгөрүүлсэнээс хойш өдгөө 24 жил болж байна. Монгол улсын хувьд энэхүү өдрийг энэ жил 14 дэх удаагаа тэмдэглэж байна.

Тус “Гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан 2016 оноос эхлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй гэр бүлүүд рүү хандсан сургалт, арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. 2016 онд нийгэмд болон бусдад сайн үлгэр жишээ болж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй 5 гэр бүлийг алдаршуулж, урамшуулсан бол 2017 онд ажил хөдөлмөрөөрөө бусдыгаа манлайлж буй нийслэлийн шилдэг 6 гэр бүлийг түүхийн дурсгалт газраар аялуулах, тэдний нийгмийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх,



нөхөрсөг уур амьсгалыг бүрдүүлсэн тэмцээн уралдаан, чөлөөт арга хэмжээг зохион байгуулсан.

Өнгөрсөн онд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах олон улсын өдөр”-ийг угтан хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй гэр бүлүүдэд дэмжлэг үзүүлэх, урам зориг хайрлах, гэр бүлийн нандин дурсамжийг бий болгох, амьдрах итгэл үнэмшлийг нэмэгдүүлэх зорилгоор Гэрлэх ёслолын ордонтой хамтран 2018 оны 10-р сарын 23-ны өдөр “Хамтдаа хайрлая” өдөрлөгийг зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй 3 хосын гал голомтыг бадрах гэрлэх ёслолыг амжилттай зохион байгууллаа.

Энэхүү арга хэмжээ нь хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэр бүлүүдийн харилцаа холбоог сайжруулах, сэтгэл санааны болон эрүүл амьдралын дадал эзэмшүүлэх, амьдралын сайн туршлагаасаа бусадтай хуваалцах, үлгэрлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх чухал ач холбогдолтой тул жил бүр уламжлал болгон хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрх, гэр бүлүүд рүү чиглэсэн арга хэмжээг зохион байгуулж ажиллах юм.



“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ НЬ САЛБАР ДУНДЫН ШИНЖЛЭХ УХААН БОЛОХ НЬ” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫГ ЖИЛ БҮР ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА

“Хөгжлийн бэрхшээл судлал нь салбар дундын шинжлэх ухаан болох нь” эрдэм шинжилгээний хурлыг 2013 оноос эхлэн өдгөө 6 дахь жилдээ зохион байгуулж байна. Өнгөрсөн жил “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах Олон Улсын өдөр”-ийг тохиолдуулан “Хүртээмжтэй нийгмийн төлөө хүн бүрийн оролцоог дэмжье” сарын аяны хүрээнд “Хөгжлийн бэрхшээл судлал нь салбар дундын шинжлэх ухаан болох нь” эрдэм шинжилгээний хурлыг 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсан.

Эрдэм шинжилгээний хуралд хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, их, дээд сургуулийн оюутан, ажилтан, судлаач, эрдэмтэд оролцдог ба ирүүлсэн бүтээлийг хэлэлцүүлж ач холбогдол, шинэлэг санаа дэвшүүлсэн байдал, асуудал дэвшүүлж, зорилгодоо хүрсэн байдал, судалгааны арга аргачлал, илтгэх ур чадвар, цаг ашиглалт зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан шалгаруулдаг. Түүнчлэн эрдэм шинжилгээний хуралдаанаар дэвшүүлсэн шинэлэг санал, санаачлагууд болон зөвлөмжүүдийг цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэхэд анхаарч буйгаас гадна хурлын талаарх тайлан, хураангуйг www.nrc.gov.mn сайтад жил бүр байршуулж олон нийтийн хүртээл болгож байна.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС 2019 ОНЫГ “ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ” БОЛГОН ЗАРЛАЛАА

Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн ээлжит хуралдаанаар 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ээр зарлаж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталлаа.

Тус жилийн хүрээнд иргэдийн хэрэгцээнд суурилсан төрийн үйлчилгээ, ил тод байдал, иргэний оролцоотой шийдвэр гаргах, төрийн үйлчилгээний оновчтой чиг үүргийг бий болгох, үр дүнд суурилсан удирдлага, иргэн төвтэй төрийн алба гэсэн таван

үндсэн зорилтын хүрээнд 70 орчим арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Монгол Улсын Засгийн газар төрийн албаны шударга байдал, иргэдээ дээдэлсэн төрийн үйлчилгээ, сахилга хариуцлагыг бэхжүүлэх нь хөгжлийн нэг тулгуур гэж тодорхойлж иргэдийн хэрэгцээ, шаардлагыг ойлгож, түүнд нийцүүлсэн төрийн үйлчилгээг төлөвлөх шаардлагатай гэж үзэн 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ээр зарласан байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ, ХАНДЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛГО БҮХИЙ “САРЫН АЯН”-ЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА

“Оюуны бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг угтан Эпилепси буюу уналт таталт, Даун, Аутизм зэрэг оюуны хөгжлийн бэрхшээлүүдийг нийгэм, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор 2019 оны 03 сарын 21-ны өдрөөс 2019 оны 04 сарын 11-ны өдрүүдэд сарын аяныг зарлан амжилттай зохион байгуулж өндөрлөлөө. Тус аяны хүрээнд:

- “Оюуны бэрхшээлтэй хүүхдүүдэд тулгамдаж буй асуудал, цаашид шийдвэрлэх арга зам” сэдэвт ХБХХЕГ, СЗСҮТ, ТББ-ын хамтарсан уулзалт, хэлэлцүүлэг;
- Оюуны бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд Бочче тэмцээн;
- Оюуны бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагч нарт хөдөлгөөн заслын талаарх сургалт;
- Оюуны бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх сэргээн засах тусламж үйлчилгээ зэрэг арга хэмжээг тус тус зохион байгууллаа.

Мөн аяны хүрээнд “Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх өдөр”-ийг угтан үндэсний цэцэрлэгт хүрээлэнд

Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран 2019 оны 5 дугаар сарын 04-ны өдөр “ӨНӨӨДӨР НӨЛӨӨЛЖ, МАРГААШ ӨӨРЧИЛБЕ” өдөрлөгийг зохион байгуулах гэж байна. Тус өдөрлөгөөр хөгжлийн бэрхшээлээс урьчилан сэргийлэх үзлэг, хууль эрх зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүтээлийн үзэсгэлэн, “Бид өөрчлөгчид” флашмоб зэрэг олон талт арга хэмжээ зохион байгуулагдана.



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАН АЖИЛЛАХААР БОЛЛОО

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01 дүгээр тогтоолын тавдугаар хавсралтаар батлагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг худалдан авах тухай хууль болон бусад холбодох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт нийцүүлсэн байнгын ажлын байр бий болгох санхүүгийн дэмжлэгийн тэргүүлэх чиглэл, тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийг аж ахуй нэгж, төрийн бус байгууллагуудын саналыг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлөөр батлуулаад байна. Тус хөтөлбөрийн хүрээнд аж ахуй нэгж байгууллагад эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр 50,0 хүртэлх сая төгрөг, ТББ-д 30,0 хүртэлх сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх юм.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ХҮРТЭЭМЖТЭЙ ШИЛДЭГИЙГ ШАЛГАРУУЛНА

2016 онд Улсын Их Хурлаар хэлэлцэн баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулинд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийтийн тээвэр, зам, орон сууц, олон нийтийн барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх болон тэдний бусад эрхийг хуульчилсан төдийгүй төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх үүрэг, оролцоог мөн тодорхойлж өгсөн юм.

Тус хуулийн хэрэгжилтийг хангахад Засгийн газраас ихээхэн анхаарал хандуулж байгаа бөгөөд иргэд, олон нийт, аж ахуйн нэгж байгууллагуудыг шалгах, торгууль ногдуулахаас илүүтэй хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг урамшуулах, тэдний сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг

чиглэл болгож байгаа билээ. Энэ хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэгийг шалгаруулах журам”-ыг баталсан. Тус журмын хэрэгжилтийг хангах хүрээнд ХНХЯ, ХБХХЕГ хамтран ирэх 6 дугаар сард Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй, хүртээмжтэй орчин бүрдүүлэх, тэдний нийгмийн амьдралд оролцох оролцоог дэмжих, ажлын байраар хангах, зэрэг чиглэлээр идэвх, санаачилга гарган ажилласан шилдэг аж ахуйн нэгж байгууллага, иргэд, албан хаагчдыг шалгаруулж, алдаршуулах арга хэмжээг зохион байгуулах гэж байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ОРОН ТООНЫ БУС САЛБАР ЗӨВЛӨЛТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА



Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 136 дугаар тогтоолоор холбогдох төрийн байгууллага, мэргэжлийн холбоод, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын төлөөлөөс бүрдсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийг байгуулсан. Зөвлөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, салбар дундын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэгтэй ажиллах юм.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 9 дүгээр сарын 14-ны өдрийн 289 дүгээр тогтоолоор тус зөвлөлийн даргаар

хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Дэд зөвлөлийг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга нар, Салбар зөвлөлийг аймаг, нийслэл, дүүргийн засаг дарга нар тус тус ахлан ажиллаж байна.

ХБХХЕГ нь чиг үүргийнхээ хүрээнд орон нутаг дахь орон тооны бус салбар зөвлөлүүдтэй хамтран ажиллаж, 2019 онд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд дараах чиглэлийг хүргүүлэн батлуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллалаа. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах, сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллах;

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг сурталчилах, борлуулах цэгийг өөрийн орон нутагт шинээр бий болгох;

3. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гамшгийн эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй хүн болон тэдний асран хамгаалагч нарт гамшгийн сургалт зохион байгуулах;

4. Зам, тээврийн дэд бүтэц болон нийгмийн үйлчилгээний бусад барилга, байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх.

Цаашид орон тооны бус салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулах, удирдлага арга зүйгээр хангах, хамтын ажиллагаа, уялдаа холбоог бэхжүүлэх, хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор нэгдсэн мэдээллийн сан үүсгэж ажиллах юм.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР ЕХ-НЫ SECIM ТӨСӨЛТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА



ХБХХЕГ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, гадаад улс орнуудын хөдөлмөр эрхлэлтийн тэргүүн туршлагуудыг түгээн дэлгэрүүлэх, мэдлэг олгох, чадавхийг бэхжүүлэх зорилгоор ЕХ-ны SECIM



төсөлтэй 2018 оноос эхлэн хамтран ажиллаж байна. Хамтын ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулаад байна. Үүнд:

❖ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр ажилд зуучлах, байнгын ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн чадвар, онцлог хэрэгцээг олон нийтэд сурталчлан таниулах зорилготой **"Career expo 2018"** арга хэмжээг өнгөрсөн оны 11 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгууллаа. Тус арга хэмжээ нь Монгол улсын хэмжээнд анх удаагаа зохион байгуулагдаж байгаа ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байранд шууд зуучилж байгаагаараа онцлогтой юм. Уг арга хэмжээг энэ онд мөн зохион байгуулахаар төлөвлөөд байна.

❖ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг

үзүүлэх, ЕХ-ны хөдөлмөр эрхлэлтийн тэргүүн туршлагуудыг түгээн дэлгэрүүлэх, мэдлэг олгох, чадавхийг бэхжүүлэх, туршлага солилцох зорилго бүхий **"ЕХ-ны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт ба бодлого"** сэдэвт сургалтыг энэ оны 02 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд ХНХЯ, түүний харьяа байгууллагуудын хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр ажилладаг албан хаагчдад зохион байгуулсан.

❖ Амжилттай хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг алдаршуулах, урам зориг, эрч хүч бэлэглэх, тэдний сайн туршлагыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор амжилттай хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн танилцуулга, мэдээллээр эмхтгэл бэлтгэн нийтлүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

ЖАЙКА ОУБ-ЫН "УБ ХОТ ДАХЬ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН НИЙГМИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ" ТӨСӨЛТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА

2013 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх болон нийгмийн оролцоотой холбоотой ойлголт хандлагууд нийгэмд идэвхтэй болж ирсэн. Гэсэн хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьжиргааны төвшин доогуур байсаар байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээнд нийцсэн тусгай тохируулга бүхий ажлын байр байхгүйгээс хөдөлмөр эрхлэлтэд ахиц дэвшил гарахгүй байна. Нийтийн тээвэр, барилга байгууламжийн саадгүй байдал, цахим тоног төхөөрөмж зэрэг мэдээллийн хүртээмжтэй байдал, халамжийн туслах хэрэгсэл гэх мэт зүйлс дутагдалтай байгаа. Мөн түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллага, дэмжигч байгууллагуудыг хамруулсан чадавхжуулах сургалт хангалттай явагддаггүй бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог бодитой болгох үндэс суурь бэхжээгүй байна.

Эдгээр нөхцөл байдлыг анхааралдаа авч Монголын засгийн газар Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн

нийгмийн оролцоог дэмжих төсөл хэрэгжүүлэх талаар Японы засгийн газарт санал тавьснаар уг төсөл хэрэгжих эхлэлийг тавьсан.

Энэхүү төсөл нь 2016 оноос эхлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн санг бүрдүүлэх, ТББ-г чадавхжуулах, дэд бүтэц болон мэдээллийн хүртээмжийг сайжруулах, хөгжлийн бэрхшээлийн талаарх зөв ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжиж суурь систем, тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр ХНХЯ болон ХБХХЕГ-тай харилцан уялдаа холбоотой хамтран ажиллаж байгаа билээ. Бид бүхний хувьд Япон улсын болон төсөл хэрэгжүүлж буй багийнхнаас туршлага судлах, дүн шинжилгээ хийх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээнийхээ чиглэлийг тодорхойлох, боловсон хүчнээ чадавхижуулах, цаашлаад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ эрхийг хамгаалах, хөгжлийг дэмжиж, оролцоог нэмэгдүүлэхэд анхаарал хандуулан хамтран ажиллаж байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын адил нийгмийн харилцаанд эрх тэгш оролцох, тэдний эрхийг хангах, хуулийн хэрэгжилтийг сайжруулахад төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа нэн чухал байна. Улсын хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 80 гаруй төрийн бус байгууллага байна гэсэн албан бус судалгаа байдаг. Иймд эдгээр байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог бэхжүүлэх, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, тэдний дуу хоолойг шийдвэр гаргах түвшинд хүргэх зорилгоор ХБХХЕГ нь сар бүр ТББ-ууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангасан **"ХБИБ-ын уулзалт"**-ыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

Цаашид төрийн бус байгууллагуудын шинэчилсэн бүртгэл, судалгаа бүхий мэдээллийн санг үүсгэх, бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ТББ-ын оролцоог хангах, тэнцвэртэй жигд хамруулах, тэднийг мэдээ, мэдээллээр хангах, харилцан туршлага солилцох, чадавхижуулах болон нэгдмэл байдлыг бий болгох чиглэлийг баримтлан ажиллах юм.



“Байгууллагын үйл ажиллагааг өргөжүүлэх, олон улсын түвшинд хүргэх” стратегийн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд ХБХХЕГ нь дараах олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоон, харилцан туршлага, мэдээлэл солилцох, олон талт сургалт, арга хэмжээг зохион байгуулах зэргээр хамтран ажиллаж байна.

- Европын Холбоо
- “ЖАЙКА” Олон улсын хамтын ажиллагааны байгууллага
- Олон улсын хөгжлийн бэрхшээлийн байгууллага
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
- Азийн хөгжлийн банк
- Олон улсын хөдөлмөрийн байгууллага
- КОЙКА Олон улсын хамтын ажиллагааны байгууллага

- БНСУ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн хүрээлэн
- БНСУ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн агентлаг
- “Дэлхийн зөн” ОУБ
- Италийн “АЙФО” ОУБ
- “ДЕЗЕРЕТ” ОУ-ын энэрэлийн байгууллага
- Олон улсын сэргээн засах байгууллага
- Австралийн сайн дурын байгууллага
- АНУ-ын ЭСЯам
- Монгол дахь Хятадын хөрөнгө оруулагчдын Зунхуа нийгэмлэг
- Тайпейн худалдаа, эдийн засгийн Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙГ ХАМТ ОЛОНД ТҮШИГЛЭН ХАМРУУЛАН ХӨГЖҮҮЛЭХ АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮСИЙН 4 ДҮГЭЭР КОНГРЕСС БОЛНО



Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх IV конгресс МУ-ын нийслэл Улаанбаатар хотноо 2019 оны 7-р сарын 2,3-ны өдрүүдэд Шангри Ла зочид буудалд зохион байгуулагдах гэж байна.

Конгрессын үйл ажиллагаа нь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтэд илүү анхаарал хандуулж буй илэрхийлэл болгож “Эдийн засгийн тогтвортой хөгжилд хөгжлийн бэрхшээлийг тэгш хамруулах, чадавхийг дээшлүүлэх” зорилгоор Ази, номхон

далайн бүсийн орнуудын 600 гаруй төлөөлөгчид өөрсдийн орны сургамж болон сайн туршлагаа хэлэлцэх юм.

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын хүрээнд цаашид хамтарч ажиллах Засгийн газрын төлөөлүүд, ХБИ-ийн байгууллагуудын үндэсний холбоо, иргэний нийгмийн байгууллагууд, ОУ-ын төрийн бус байгууллагууд болон Ази, Номхон далайн бүсийн орнуудын цаашдын хамтын ажиллагааг бэхжүүлэхийг зорьж байна.

Конгрессыг МУ-ын Засгийн газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Ази, номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх сүлжээний байгууллагууд болох Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, НҮБ-ын Ази, номхон далайн бүс нутгийн Эдийн засаг-Нийгмийн Комисс, Япон улсын ЖАЙКА ОУБ-ын Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл, Леонард Чеширийн хандивын байгууллага, Амичи Ди Раул Фолеро буюу Раул Фолерогийн анд нөхдийн холбоо-Италийн ТББ (АЙФО), СВМ, Ази-номхон далайн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн төв зэрэг байгууллагууд хамтран зохион байгуулна.



ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООЛОО

Хөдөлмөрийн тухай хуулийн 111.2-т заасны дагуу Аж ахуйн нэгж, байгууллага хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлөх ёстой байдаг. Тус төлбөрийн хэмжээг хөдөлмөрийн тухай хуулийн 111.3-т зааснаар аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын тоо, төлбөрийн нийт хэмжээнээс

хамааран Засгийн газраас тогтооно гэж заасныг үндэслэн Монгол Улсын засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 111 дугаар тогтоолоор Аж ахуйн нэгж байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүнийг ажиллуулаагүй орон тоо тутамд сар бүр төлөх төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоосон байна.

АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГААС ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ БУЮУ ОДОЙ ХҮНИЙГ АЖИЛЛУУЛААГҮЙ ОРОН ТОО ТУТАМД САР БҮР ТӨЛӨХ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

№	Аж ахуйн нэгж байгууллагын ажиллагчдын тоо (бүсээр)	Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүнийг ажиллуулах орон тоог аж ахуйн нэгж байгууллагын нийт ажиллагчдын 25 хүн тутамд 1 гэж тооцох
1	Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул аймаг	Тухайн байгууллагад ажиллагчдын дундаж цалингийн хэмжээгээр
2	Бусад аймаг	Тухайн байгууллагад ажиллагчдын дундаж цалингийн 60 хувиар



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙГ ХҮЛЭЭЖ АВЛАА





БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар баригдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийг Монгол Улсад хүлээлгэж өгөх ёслолын ажиллагаа 2019 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр боллоо.

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй 105 мянга гаруй иргэн байгаагийн 14 мянга орчим нь 0-17 насны хүүхэд байна. Эдгээр хүүхдийг хөгжих, төлөвших, хүмүүжих нөхцөл бололцоогоор хангах, нөхөн сэргээх эмчилгээнд хамруулахын хамт хүүхдүүдийг хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх нь төр, засгийн бодлого үйл ажиллагааны нэг чиглэл бөгөөд энэ хүрээнд хийсэн томоохон

ажлын нэг нь энэхүү Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв болж буй юм. Тус төв нь хөгжлийн бэрхшээлтэй 250 хүүхдэд өдрөөр эмчилгээ үйлчилгээ үзүүлэхээс гадна 250 хүүхдийг хэвтүүлж эмчлэх хүчин чадалтай нөхөн сэргээх энэхүү төв ашиглалтанд орсноор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг цаг алдалгүй эмчлэх, сэргээн засах үйлчилгээг үзүүлэхийн хамт хөгжлийн бэрхшээлийг эрт үед нь оношлох, урьдчилан сэргийлэх чиглэлээр илүү нарийн үзлэг, шинжилгээ хийгдэх юм. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдэд зориулсан сургалт явуулах, асаргаа сувилгааны мэдлэг олгох боломж бүрдэж буй нь Монгол Улсын Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэд тэр дундаа хүүхдүүдийг онцгойлон анхаарч, тэдний хөгжлийг дэмжиж байгаагийн нэг илрэл буйза.


БНХАУ олон улсын стандартад нийцсэн орчин үеийн нөхөн сэргээх төвийг хоёр жил хагасын дотор барьж Монголын талд хүлээлгэн өгч буй юм. Ашиглалтад хүлээж авсан тус төв нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дэргэд ажиллах юм.

ХБХХЕГ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвд өдөрт хөгжлийн бэрхшээлтэй 500 хүүхэд эцэг эхийн хамт сэргээн засах эмчилгээ, өдрийн үйлчилгээ, түр байршуулан сэргээн засах үйлчилгээ, явуулын үйлчилгээ, сургалт гэсэн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж, хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт, хөгжлийг дэмжих хөтөлбөр, техник, технологийг эмчилгээ, оношилгоонд өргөн нэвтрүүлэх, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн сэргээн засалтыг цогцоор нь үзүүлэх, нотолгоонд суурилсан сэргээн засах тусламжийг нэвтрүүлэх гэсэн стратегийн тэргүүлэх чиглэлүүдийг баримтлан ажиллана.



ЗӨВЛӨГӨӨ

ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?



Тэргэнцэр арчлах зааварчилгаа

- Сард нэг удаа шалгах
- Урагдаж элэгдсэн эсэхийг шалгах
- Ямар нэг асуудал байвал “тэргэнцрийн засвар үйлчилгээний төв”-д хандах хэрэгтэй
- Бүсээ чангалсан байх
- Олбог бохирдсон тохиолдолд угаах
- Олбог хатсаны дараа тэргэнцэр дээрээ тавих
- Олбогоо наранд удаан бүү тавь

Тоормос

- Хөдөлж байх үед гараа бүү тоормосон дээр тавь

Дугуйнууд


- Дугуйнууд тань чөлөөтэй эргэхгүй бол холхивчоо солих шаардлагатай
- Дугуйныхаа хийг сард нэг удаа шалгах
- Дугуй хагарсан бол тэр дор нь засах
- Дугуйны хигээс чанга эсэхийг сард нэг удаа шалгах

Урд дугуйнууд

- Дугуйнууд чөлөөтэй хөдлөхгүй бол холхивчоо солих шаардлагатай

Хөлийн тавиур

- Хөдөлж байхад гараа хөлийн тавиур дээр бүү тавь
- Хөлийн тавиур дээрээ зогсох эсвэл ачаа бүү тавь



Нуруу нь өвддөг хүн хэр олон бэ?

Манай улсад хоёр хүн тумын нэг нь нуруугаар өвддөг гэсэн хэвлэлээр гарч байсан ч тодорхой судалгаа олдсонгүй. Нуруу нь өвддөг хүмүүсийн 15% нь л эмнэлэгт ханддаг гэнэ. Нийслэлийн томоохон эмнэлэгүүдийн нэг Шастины нэрэмжит 3-р эмнэлэгт өдөрт дунджаар 280 хүн нуруу өвдсөн гэх шалтгаанаар ханддаг байна. Тэдгээрийн 80 гаруй хувь нь 30-40 насныхан. Герман зэрэг хөгжингүй оронд нийт хүн амын 85% нь нуруугаар өвддөг гэсэн мэдээ байна.

Хөдөлгөөн буруу хийх нь нуруу өвдөх шалтгаан мөн үү?

Нурууны эмчилгээ хийдэг эмнэлгүүд буруу зөв, хөдөлгөөн гэж байдаг хэмээн үзэж байна. Хүний биеийн булчингийн зөвхөн нэгийг биш, бүх хэсгийг ажиллуулж, жигд хөдөлгөж байхын тулд олон янзын хөдөлгөөн, ачаалал хэрэгтэй байдаг. Тодруулбал янз бүрийн хөдөлгөөн биед сайнаар нөлөөлөхөөс биш тэр болгон муугаар нөлөөлөхгүй. Харин гэнэт хүнд зүйл өргөх, огцом эвгүй хөдлөх зэрэг нь түр зуурын өвдөлт үүсгэж улмаар өвчлөлд хүргэх эрсдэлтэй. Хүнд зүйлийг өргөхдөө дараах аргаар өргөж байхыг эмч нар зөвлөж байна.



Нурууны өвчин юунаас үүсэлтэй вэ?

Биеийн шалтгаан болон мөн сэтгэл санааны хүчин зүйл, өөрөөр хэлбэл стресс, сэтгэлийн дарамт зэрэг нь нурууны өвчин үүсэх гол эх үүсвэр болдог гэсэн дүгнэлт бий. Энэ талаар нарийн судалгаа, шинжилгээ байнга явуулдаг Германд нуруу нь өвдсөн өвчтөний 90 %-д нь юунаас болсон талаар тодорхой учир шалтгааныг олоогүй байна. Ийм шалтгаан нь тогтоогдоогүй үед эмч нар уг тохиолдлыг тодорхой бус нурууны өвчин гэж үздэг.

Ямар үед эмчид хандах вэ?

Нуруу өвдөхөд тэр болгон айж сандрах хэрэггүй. Яагаад гэвэл нуруу хаяа бага зэрэг өвдөх нь бидний толгой өвддөгийн нэгэн адил энгийн зүйл гэж ойлгож болно. Харин та нуруу өвдөхийн зэрэгцээ дараах тохиолдлууд илэрвэл заавал эмчид хандах хэрэгтэй. Үүнд:

- Ямар нэг онцын шалтгаангүйгээр их хэмжээгээр жингээ алдсан бол огцом турсан бол
- Нуруу өвдөх үед халуурч, хөлс их хэмжээгээр ялгарч байвал
- Хэрэв та саяхан хүнд өвчинд нэрвэгдсэн бол
- Хорт хавдар тусч байсан бол
- Давсаг султай болж, хөлийн шөрмөс татдаг бол гэх мэт шинж тэмдэг давхар илэрвэл эмчид хандаарай.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

*Хүртээтэжтэй нийгмийн төлөө
Хүн бүрийн оролцоог дэтжье!*

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, Эрхүүгийн гудамж,
Утас: **77032222, 77772001**
И-мэйл: **info@gadpwd.gov.mn**